МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.07.25 № 01/4274

танай ________ -ны № ________ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулга оруулах тухай

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан НЗДТГ/20240101013 дугаартай "Эрчим хүч хуримтлуурын станцын ажил"-ын тендер шалгаруулалтад оролцогчоос тодруулга авах хүсэлт ирсэнтэй холбогдуулан дараах тодруулгыг хавсралтаар оруулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 2.... хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1110202124

| Д/д | Оролцогчийн тодруулга | Хариулт |
|---|---|---|
| 1 | Төслийн хүрээнд SCADA систем нийлүүлж угсрах ажил байна. Одоогоор Багануурт байгаа цахилгааны дэд станц нь Siemens-н SCADA-г суурилуулсан байгаа бөгөөд захиалагч талаас уг төслийн хүрээнд хийгдэх SCADA систем дээ тавьсан шаардлага байгаа юу? Siemens-н SCADA систем суурилуулах шаардлагатай юу? | Техникийн даалгаврын 4.2.5.3-4.2.5.5-д SCADA системд тавигдах шаардлага тусгасан болно.<br>Системийн зураг төслийг боловсруулж магадлалаар орохоос өмнө ДҮТ ТӨХХК-иар хянуулах, зөвшилцөх шаардлагатай. |
| 2 | Төслийн хүрээнд ажил гүйцэтгэхэд төлбөрийн график, хугацаа болон төлөлтийн эзлэх хувь хэмжээ хэд байгаа вэ? Урьдчилгаа төлбөр байгаа юу? | ТББ-ийн Гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу Урьдчилгаа төлбөр олгохгүй.<br>Төлбөр төлөх үе шатны хугацаа:<br>- Техникийн комиссын акт албажсаны дараа<br>- Улсын комисс хүлээн авч батарей хуримтлуурын станцын үйл ажиллагаа жигдэрсний дараа |
| 3 | Захиалагч талаас төлөвлөж буй төсөл хэрэгжүүлж хүлээлгэн өгөх нийт хугацаа/эцсийн хугацаа? | - Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.<br>- Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт заасна хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд 0.1 хувиар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.<br>- Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваариас 30 хоногоор илүү өдөр хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ. |
| 4 | Ажлын төлбөрийн валют төгрөг үү эсвэл ам доллар уу? гадаадын банкны данс руу хийхээр бол яах вэ? | - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.13-т "Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг тус хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт заана." гэж заасан. |

| | | |
|---|---|---|
| | | - Тендерт оролцогчоос ирүүлсэн саналыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар гадаад валютаар ирүүлсэн тендерийн үнийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Төв банк /Монголбанк/-ны албан ханшаар тооцож хөрвүүлэх;” гэж заасны дагуу хөрвүүлж тооцно. |